

**“МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГТ ТАВИХ ШААРДЛАГА,
ЗАГВАР”-ЫГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

“Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавих шаардлага, загвар”-ыг Хөдөлмөрийн сайдын 2016 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/53 тоот тушаалаар батлуулж Хууль зүйн дотоод хэргийн яамны нийтээр дагаж мөрдөх журмын бүртгэлд 3625 дугаараар бүртгүүлэн мөрдөн ажиллаж байгаа бөгөөд дараах шаардлагын улмаас шинэчлэн боловсруулж байна.

Өнөөдрийн байдлаар төрийн өмчийн 38, төрийн өмчийн их, дээд сургуулийн дэргэдэх 11, төрийн бус өмчийн 41 МСҮТ, Политехник коллеж сургалт явуулж байна. Эдгээрээс 9 мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага суманд үйл ажиллагаа эрхэлж байна. Хөдөө орон нутаг, аймаг, сумаас МСҮТ байгуулах өргөдөл, хүсэлт олноор ирдэг. Сүүлийн үед шинээр байгуулагдах мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын тоо өсөх хандлагатай болсон нь сургалтын чанарт сөргөөр нөлөөлж байна.

1. Сургалтын байгууллагын чанарыг сайжруулах, төрөлжилт, хүн ам, нийгмийн хөгжлийн бодлогыг баримтлах үүднээс Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 334 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийгмийн үйлчилгээний жишиг норматив”-ийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу 20000-аас дээш хүн амтай бүх сум, хотод шаардлага, нормативыг хангасаны дагуу мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг байгуулахыг шийдвэрлэх талаар зохицуулалт тусгаж байна.

2. Гадаадын хөрөнгө оруулалттай, хамтарсан мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг байгуулахдаа холбогдох гэрээ, хэлэлцээр, баримт бичгийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэж, тусгай зөвшөөрлийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгох, политехник коллежоор бэлтгэх мэргэжлийн чиглэл нь 50-аас дээш хувийг техникийн боловсрол эзэмшүүлэх, төрөлжилтийн бодлого, шинээр мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа эрхлэх, шинэ мэргэжлээр сургалт эрхлэх тохиолдолд мэргэжил бүрийн чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг харьяа мэргэжлийн боловсрол, сургалтын бүсийн арга зүйн төвөөр дүгнэлт гаргуулна.

3. Одоогийн шаардлага загвараар шууд МСҮТ байгуулах боломжтой байгаа тул шинээр МСҮТ байгуулах иргэн, ААНБ нь мэргэжлийн сургалт эрхэлж байгаа туршлагатай байх талаар зохицуулалт тусгасан.

4. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага байгуулах тусгай зөвшөөрөл, хавсралтыг хаяж үрэгдүүлэх тохиолдол гарсаар байгаа тул сургалтын байгууллагын хариуцлагыг сайжруулахын тулд хаяж гэсэн тохиолдолд Улсын тэмдэгтийн тухай хуулийн 22.1.5, 22.1.6-д заасан хураамжийг төлж нөхөн олгохоор зохицуулалт тусгаж байна.

5. Сургалтын орчин, багшид тавигдах стандарт шаардлага дээр зайлшгүй холбогдох бусад стандартыг нэмж, тусгай зөвшөөрлийн талаар 2 жилд 1 удаа сайдын тушаал гаргахаар зэргээр олон заалтыг өөрчлөн найруулах, шинэ зохицуулалтыг тусгасан.

6. Одоогийн шаардлага, загвар дээр зөвхөн тусгай зөвшөөрлийн хавсралтын загварыг баталсан. Энэ удаагийн шаардлага, загварын төслөөр тусгай зөвшөөрлийн нүүр, хавсралтыг сайдын тушаалаар батлан хэвлэхээр журмын зохицуулалт тусгаснаар ач холбогдолтой юм.

7. Мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад бүрдүүлэх баримт бичгийг цөөлж, зөвхөн албан хүсэлт, хавсралтын хуулбарын хамт ирүүлэхээр туссан.

Шаардлага, загвар батлах тухай

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд тавих шаардлага, загварыг нэгдүгээр, тусгай зөвшөөрлийг хоёрдугаар, хавсралтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ц.Амартөгс/, Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтэс /А.Халиунаа/, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хянал-шинжилгээ, дотоод аудитын газар/Ц.Мөнхзул/-т даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хөдөлмөрийн сайдын 2016 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/53 тоот тушаалаар батлагдсан “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавих шаардлага”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

С.ЧИНЗОРИГ

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД
ТАВИХ ШААРДЛАГА, ЗАГВАР

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжид заасны дагуу мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл/цаашид “тусгай зөвшөөрөл” гэх/ авахад бүрдүүлэх баримт бичигт энэхүү шаардлагыг мөрдөнө.

1.2. Боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан баримт бичгийн шаардлагыг нягталж, тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, цуцлах дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газар, ажил олгогч, мэргэжлийн холбоод зэрэг төлөөллөөс бүрдүүлж, Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.

1.3. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 334 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийгмийн үйлчилгээний жишиг норматив”-ийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу 20000-аас дээш хүн амтай бүх сум, хотод болон бүсчилсэн хөгжил, хот төлөвлөлтийн бодлого, бүс нутгийн онцлогийг харгалзан зарим сумдад боловсролын стандартад заасан боловсролын агуулгын түвшин, сургалтын орчинд тавигдах үндсэн шаардлага, барилгын норм ба дүрэмд заасан нормативыг хангасан тохиолдолд мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага байгуулахыг шийдвэрлэнэ.

1.4. Гадаадын хөрөнгө оруулалттай, хамтарсан, нэрэмжит мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг байгуулахдаа холбогдох гэрээ, хэлэлцээр, баримт бичгийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэж, тусгай зөвшөөрлийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

1.5. Иргэнд мэргэжлийн анхан болон дунд шатны ур чадвар шаардагдах, төвөгшил багатай, хөдөлмөрийн зах зээлд эрэлт багатай, нийтлэг мэргэжлээр мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эсэхийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

1.6. Политехник коллежоор бэлтгэх мэргэжлийн чиглэл нь 50-аас дээш хувийг техникийн боловсрол эзэмшүүлэх сургалт давамгайлна.

1.7. Шинээр мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа эрхлэх, шинэ мэргэжлээр сургалт эрхлэх тохиолдолд мэргэжил бүрийн чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг харьяа мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ болон бүсийн арга зүйн төвөөр дүгнэлт гаргуулна.

1.8. Мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, шаардлага загвар, холбогдох хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангахгүй тохиолдолд мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын ангиллыг бууруулан тогтоож болно.

Хоёр. Тусгай зөвшөөрөл авах баримт бичигт тавигдах шаардлага

2.1. Тусгай зөвшөөрөл хүсэж буй үүсгэн байгуулагч нь Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль болон Стандартчиллын үндэсний зөвлөлөөс 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 45 тоот тогтоолоор баталсан “MNS 6541:2015, Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага”, “Олон нийт, иргэний барилгын БНБД-31-03-03, Барилгын норм ба дүрэм (БНБД-II-66-88)”, “Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага /MNS 5742: 2007/”-ыг тус тус хангасан байна.

2.2. Шинээр мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх, мэргэжлийн боловсрол, сургалтын шинэ мэргэжлээр сургалт явуулах, захиалгат сургалт явуулахад дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

2.2.1. Шинээр мэргэжлийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэхэд загвар /1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11/-ын дагуу хүсэлт гаргаж, ирүүлнэ.

2.2.2. Шинэ мэргэжлээр сургалт явуулахад загвар /12, 13/-ын дагуу хүсэлт гаргаж, ирүүлнэ.

2.2.3. Техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэхэд загвар /6, 7, 8, 12, 15/-ын дагуу хүсэлт гаргаж, ирүүлнэ.

2.2.4. Сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага захиалгат сургалт зохион байгуулахад загвар /12/-ын дагуу хүсэлт гаргаж, ирүүлнэ.

2.2.5. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад загвар /14/-ын дагуу хүсэлт гаргаж, ирүүлнэ.

2.2.6. Шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, харьяа дүүргийн нийгмийн даатгал, татварын алба болон харилцагч банкнаас санхүүгийн болон байгууллагын чадамжаа илэрхийлсэн тодорхойлолтыг ирүүлнэ.

2.3. Үүсгэн байгуулагч тухайн мэргэжлийн чиглэлээр сургалт явуулах үндэслэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, сургалтын байгууллага байгуулах хэрэгцээ, мэргэжлийн боловсрол, сургалтын стандартын шаардлага, сургалтын орчин нөхцөлийн бүрдүүлэлт /өөрийн эзэмшлийн байр, газар/, үүсгэн байгуулагчийн санхүүгийн чадавхи, тооцоо судалгаа нь тусгай зөвшөөрөл олгох үндсэн шаардлагыг хангах үндэслэл болно.

2.4. Сургалтын ажлыг эхлүүлэх болон цаашид бүрэн хүчин чадлаараа ажиллах хүртэлх суралцагчийн тооны төлөв, нэг багшид ногдох суралцагч, сургалтын төлбөрийн хэмжээ, тогтоосон үндэслэл, төсвийн төсөөллийг гурван жилээр тооцож хавсаргасан байна.

2.5. Сургалтын байгууллага нь нийт багш нарын 80-аас доошгүй хувийг мэргэжлийн үндсэн багш байхаар бүрдүүлсэн байна.

2.6. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш нь мэргэжлийн зэрэгтэй, тухайн чиглэлээр 3-аас доошгүй жилийн ажлын дадлага, туршлагатай, мэргэжлийн боловсрол, сургалтын заах арга зүйн сургалтад хамрагдаж, багшлах эрх авсан байх бөгөөд нотлох баримтыг бүрдүүлж ирүүлнэ.

2.7 Сургуулийн зориулалтын барилга байгууламж нь үүсгэн байгуулагчийн эзэмшлийн өмч болохыг нотлох үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, барилга байгууламжийн зохион байгуулалт, давхаруудын зураглал, бүтэн харуулсан гэрэл зураг хавсаргасан байна.

2.8. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4-д заасан улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт бүрдүүлэхтэй холбогдох асуудлыг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.5, 22.1.6, 42 дугаар зүйлд заасны дагуу баримт бүрдүүлж, ирүүлнэ.

2.9. Шинээр мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын үүсгэн байгуулагч нь мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа эрхэлсэн 5-аас доошгүй жилийн туршлагатай байна. Гэрчилгээний хугацаа хүчин төгөлдөр байна.

2.10. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагаас Политехник коллеж болоход байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг хийлгэсэн байна.

2.11. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь эдийн засгийн бүс, бүсчлэл, газар нутгийн байршлаасаа хамаарч зонхилох мэргэжлийн чиглэлийн сургалтын хөтөлбөрөөр төрөлжинө. Дагалдах мэргэжлийн чиглэлийн сургалтын хөтөлбөрүүдээр үйл ажиллагаа эрхэлж болно.

2.12. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь салбар байгуулах, өөр газар шилжүүлэн сургалтын үйл ажиллагаа явуулах тохиолдолд шинээр мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага байгуулахтай адилаар шийдвэрлэнэ.

Гурав. Бусад

3.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага үүсгэн байгуулагч нь тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг баримт бичгийн хамт сургалтын үйл ажиллагаа эхлэхээс 6-аас доошгүй сарын өмнө мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

3.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага шинэ мэргэжлээр сургалт явуулах тусгай зөвшөөрөл авах, техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх хүсэлтийг тухайн сургалт эхлэхээс 5-аас доошгүй сарын өмнө мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

3.3. Төр засгийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, шинэ техник, технологи нэвтрүүлэх, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх тохиолдолд шинэ мэргэжил нээх хүсэлтийг хугацаа харгалзахгүй хүлээн авч шийдвэрлэж болно.

3.4. Боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан баримт бичиг болон энэхүү тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавих шаардлага хангасан тохиолдолд тусгай зөвшөөрөл олгоно.

3.5. Энэхүү журмын дагуу тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангасны дараа холбогдох баримт бичгийг өргөдлийн хамт мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

3.6. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг энэхүү журмын 1.2-д заасны дагуу олгох болон 1.3, 1.5-д заасны дагуу 2 жилд 1 удаа мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

3.7. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад шинэ мэргэжлээр сургалт явуулах тусгай зөвшөөрөл олгоход шинэ мэргэжил бүрээр 150000 төгрөгийн улсын тэмдэгтийн хураамж төлнө.

3.8. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага байгуулах тусгай зөвшөөрөл, хавсралтыг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд Улсын тэмдэгтийн тухай хуулийн 22.1.5, 22.1.6-д заасан хураамжийг төлж нөхөн олгоно.

3.7. Тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, татан буулгах асуудлыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11-14 дүгээр зүйл, Боловсролын тухай хуулийн 21-25 дугаар зүйл, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу тус тус зохицуулна.

---oOo---

Загвар 1
Огноо:

СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад

Өргөдөл гаргагчийн ургийн овог, эцэг эхийн нэр, өөрийн нэр:
Албан ёсны хаяг: /нэр, албан тушаал, хаяг, утас, факс, цахим шуудангийн хаяг/
Сургалтын байгууллагын нэр:
Сургалтын байгууллагын хэв шинж:

Санал болгож буй нөхцөлүүд														
№	Мэргэжлийн нэр	Мэргэжлийн индекс	Сургалтын хэлбэр	Элсэгчдийн тоо	Сургалтын агуулгын багтаамж (чадамж, багц цаг)	Багшлах бүрэлдэхүүн				Сургалтын орчин (нэрээр бичих)				Төгсөгчдөд олгох боловсролын баримт бичиг:
						Үндсэн	Цагийн	Онолын	Дадлагын	Онолын анги	Дадлагын газар	Номын сан	Бусад	
1														
2														

Өргөдөлд хавсаргах баримт бичгүүд:

1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэний үнэмлэхний хуулбар
2. Сургууль байгуулах тухай үүсгэн байгуулагчийн шийдвэр, дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө
3. Үүсгэн байгуулагчийн бүртгэл, /Төрийн албан хаагчийн 1-р маягтын дагуу/
4. Сургуулийн дүрэм, мөрдөх эрх зүйн бичиг баримтууд
5. Сургалт эрхлэх мэргэжил бүрийн чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн дүгнэлт - мэргэжлийн түвшин, чадамжаар; сургалтын төлөвлөгөө- сургалтын хэлбэрээр; /Загвар 4, 5, 6/
6. Багшлах боловсон хүчин, хүний нөөц /Загвар 7/
Сургуулийн байр, эзэмшил газрын зөвшөөрөл, гэрээ хэлцэл /нотариатаар баталгаажуулсан/
7. Сургалтын тоног төхөөрөмжийн жагсаалт /Загвар 8/
8. Сургалтын хэрэглэгдэхүүн, ном сурах бичгийн жагсаалт /Загвар 8/
9. Санхүүгийн эх үүсвэр, түүний баталгаа, сүүлийн 3 жилийн санхүүгийн аудитаар баталгаажсан тайлангийн хуулбар
10. Үүсгэн байгуулагчаас сургуулийн мэдэлд шилжүүлэх материаллаг болон мөнгөн хөрөнгийн жагсаалт, хэмжээ, баталгаа
11. Сургалтын байгууллага байгуулах үндэслэл, тооцоо бүхий танилцуулга
12. Хуудас тус бүрийг дугаарлаж баталгаажуулсан байх

Өргөдөл гаргасан:()

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2018 оны 03 дугаар сарын...ны өдрийн А/...
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Загвар 2

СУРГУУЛЬ БАЙГУУЛАХ ТУХАЙ ШИЙДВЭР

Сургууль байгуулах тухай үүсгэн байгуулагчдын анхны хурлын тэмдэглэл

1. Огноо
2. Хурал хийсэн газар
3. Хурлаар хэлэлцсэн асуудал
4. Оролцогчдын нэрс
5. Биеэр оролцоогүй үүсгэн байгуулагчдын нэрс
6. Хурлаас гаргасан шийдвэр

Хуралд оролцогчдын гарын үсэг:

Анхны хурлын шийдвэрт заавал тусгасан байх зүйл:

1. Сургууль байгуулах үүсгэн байгуулагч бүрийн анкет, /Төрийн албан хаагчийн 1 дүгээр маягт/ хүлээх үүрэг, хариуцлага
2. Сургууль байгуулах бэлтгэлийг хангах үйл ажиллагааны тойм, төлөвлөгөө

Загвар 3

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН БҮРТГЭЛ

№	Овог, нэр	Регистрийн дугаар	Одоо эрхэлж буй ажил	Боловсролын салбарт ажилласан байдал

Тайлбар:

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017.01.27-ны А/19 “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм, Удирдах зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм батлах тухай” тушаал үзнэ үү. /Тушаал шинэчлэгдсэн бол сүүлийн тушаал хүчинтэй./
2. Удирдах зөвлөлийн гишүүн тус бүрийн анкетийг Төрийн албан хаагчийн 1 дүгээр маягтын дагуу гаргаж хавсаргана.

Үүсгэн байгуулагчдын ахлагч ()

... он ... сар ... өдөр

Загвар 4

Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн загвар

Хөдөлмөрийн сайдын 2015 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн “Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн загвар батлах тухай” А/197 дугаар тушаалаар батлагдсан загварын дагуу сургалтын хөтөлбөрийг боловсруулж, харьяа мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ болон бүсийн арга зүйн төвөөр хянан баталгаажуулсан дүгнэлтийг ирүүлсэн байна.

Загвар 5

Сургалтын төлөвлөгөө

"....." МЭРГЭЖЛИЙН
ЧАДАМЖИД СУУРИЛСАН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Мэргэжил:

Түвшин:

Чадамжийн нэгжийн тоо:

Индекс:

Суралцах хугацаа:

Элсэгчид:

1. Ерөнхий суурь чадамжийн хүрээнд....
2. Мэргэжлийн суурь чадамжийн хүрээнд...
3. Мэргэшүүлэх чадамжийн хүрээнд...

№	Чадамжийн нэгжийн нэр	Чадамжийн нэгжийн код	Нийт мөдлэг, ур чадвар олгох цаг (5+6+7)	Мөдлэг олгох цаг	Ур чадвар олгох цаг		Үнэлгэ Чадамжийн нэгж бүрээр /
					Сургалтын байгууллага дээрх цаг	Ажил олгогч дээрх цаг	
0	1	2	4	5	6	7	8
А. Ерөнхий суурь чадамжийн хүрээ			0	0	0	0	
1							
2							
3							
4							
5							
6							
Б. Мэргэжлийн суурь чадамжийн хүрээ			0	0	0	0	
7							
8							
9							
10							
11							
В. Мэргэшүүлэх чадамжийн хүрээ			0	0	0	0	
14							
15							
Дүн			0	0	0	0	
Харьцаа: Мөдлэг-20%, дадлага /ур чадвар/-80%							

Тайлбар: /Материалаа бүрдүүлж өгөх үед сургалтын төлөвлөгөөний загвар өөрчлөгдсөн бол шинэчилсэн загвараар сургалтын төлөвлөгөөгөө хийж ирүүлж байхыг анхаарна уу.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2018 оны 03 дугаар сарын...ны өдрийн А/...
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Загвар 6

Техникийн боловсролын сургалтын хөтөлбөр

Хөдөлмөрийн сайдын 2015 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Техникийн боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулах загвар батлах тухай” А/262 дугаар тушаалаар батлагдсан загварын дагуу сургалтын хөтөлбөрийг боловсруулж, харьяа мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлэгээ болон бүсийн арга зүйн төвөөр хянан баталгаажуулсан дүгнэлтийг ирүүлсэн байна.

Загвар 7

БАГШ НАРЫН СУДАЛГАА

№	Багшийн овог, нэр	Мэргэжил, боловсролын түвшин			Мэргэжлийн зэрэг			Үйлдвэрлэлийн ажлын туршлага	Заах хичээл /чадамжийн нэгж (кодыг бичих)
		доктор	магистр	бакалавр	Заах аргач	Тэргүүлэх	Зөвлөх		

Жич: Багшийн анкетийг Төрийн албан хаагчийн 1 дүгээр маягтын дагуу гаргаж тухайн багшийн ажил байдлын тодорхойлолтыг хавсаргана.

Зөвшөөрсөн:...../...../
Хянасан:/...../

Огноо.....

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2018 оны 03 дугаар сарын...ны өдрийн А/...
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Загвар 8

СУРГАЛТЫН ОРЧИНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Сургалт зохион байгуулах анги, дадлагын газар:

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 45 тоот тогтоолоор баталсан “MNS 6541:2015, Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага”-ыг баримтлана.

Зүйл	Тодорхойлолт	Норм/Үзүүлэлт
Сургуулийн барилга байгууламж	Барилга байгууламж барих зөвшөөрөлтэй байх	
	Зориулалтын барилга, байгууламж	Хэмжээ Талбай/Эзлэхүүнийг заах/ Онолын хичээлийн байр Дадлагын газар Лаборатори Бусад /Олон нийт, иргэний барилгын БНБД-31-03-03, Барилгын норм ба дүрэм (БНБД-II-66-88)-д заасан байр, талбайн хэмжээ, эрүүл ахуйн болон холбогдох нормативийг хангах;/
	Байгальд ээлтэй, хүнд хор нөлөөгүй	Мэргэжлийн хяналтын дүгнэлт
	Суудлын тоо	
	Багтаамж	
	Цахим номын сан	Тоо хэмжээг заана уу.
	Номын сан	Талбай/Эзлэхүүнийг заана уу. Тоо хэмжээг заана уу.
	Соёл, спортын танхим	хэмжээ м ² харьцаа
	Дотуур байр	Хүчин чадал /орны тоо/
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн суралцах боломж	
Сургалтын орчин	Бие засах газар	
	Агааржуулалт/халаалт	
	Шалны төрөл	
	Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл	Нэр, тоо ширхэг, техникийн үзүүлэлт, нэг хүүхдэд ноогдох тоо хэмжээ
	Багшийн өрөө	
	Хувцас солих өрөө	
	Багаж хэрэгсэл, материалын өрөө	
	Цахилгааны угсралт	
	Гал унтраах/ хамгаалах хэрэгсэл	
	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хэрэгсэл	
	Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх хэрэгсэл	
	Цэвэр бохир ус	
	Бие засах газар	
Номын сан	“Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага :/MNS 5742: 2007/-г хангах	

Боловсруулсан:

Зөвшөөрсөн: Хянасан:

/...../

/Захирал/

Огноо.....

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2018 оны 03 дугаар сарын...ны өдрийн А/...
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**СУРГУУЛИЙН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧААС СУРГУУЛЬД НИЙЛҮҮЛЭХ
ЭРГЭЛТИЙН БОЛОН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ**

№	Нэр, төрөл	Ашигл алтад орсон он, сар	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн өртөг	Нийт өртөг	Ашиглалтын хугацаа	Зориулалт	Ашиглал тын талаарх тайлбар

Үүнээс гадна заавал бүрдүүлэх материал:

1. Үүсгэн байгуулагчийн санхүүгийн чадавхийг харуулсан нотлох баримт /хөрөнгийн өмчлөгч болохыг нотлох гэрчилгээ/
2. Үндсэн ба эргэлтийн хөрөнгийн өмчлөгч болохыг нотлох гэрчилгээ. Хэрэв аж ахуй нэгж байгууллага сургалтын үйл ажиллагаа эрхлэх бол тухайн сургалтын байгууллагын бие даасан хуулийн этгээд болохыг санхүүгийн хувьд тодорхойлох эхлэлтийн баланс
3. Үүсгэн байгуулагч нэг буюу түүнээс дээш тохиолдолд сургалтын байгууллагын мэдэлд шилжүүлэх хөрөнгийн баталгааг үүсгэн байгуулагчийн хурлын тэмдэглэлээр баталгаажуулсан байна. Хэрэв нэг гишүүнтэй этгээд үүсгэн байгуулагч бол шилжүүлэх хөрөнгийн өмчлөх эрхийг баталгаажуулсан байна.

Эдийн засаг, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан маягтын дагуу сургалтын байгууллагын мэдэлд шилжүүлсэн үндсэн хөрөнгийн бүртгэлийн задаргааг жагсаалтаар гаргасан байна.

1. Харьяа татварын байгууллагад өр төлбөргүй, үл хөрөнгийн барьцаагүй болохыг нотолсон бүртгэх байгууллагын тодорхойлолт
2. Банкнаас олгосон өр зээлийн талаарх тодорхойлолт

Жич: Гадаад валютаар үнэлэгдсэн зүйлсийг Монгол банкны 20 ... оны ... сарын ... өдрийн ханшаар 1\$-ыг ... төгрөгөөр ... тооцож бүгд дүнг гаргав.

Зөвшөөрсөн/Хянасан: ()

Судалгаа гаргасан: ()

Огноо:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2018 оны 03 дугаар сарын...ны өдрийн А/...
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АСУУЛТ		Эхний хичээлийн жил (20...-20...)	Хоёр дахь хичээлийн жил (20...-20...)	Гурав дахь хичээлийн жил (20...-20...)	Дөрөв дэх хичээлийн жил (20...-20...)	Тав дахь хичээлийн жил (20...-20...)	
ОРЛОГО	Орлогын нийт дүн						
	Үүнээс	Улсын төсөв					
		Үүсгэн байгуулагчаас оруулсан хөрөнгө					
		Сургалтын төлбөр					
		Хандив					
		Зээл тусламж					
		Эрдэм шинжилгээний ажил эрхлэлтээс орох орлого					
		Өөрийн үйл ажиллагаанаас олох орлого					
	Бусад						
ЗАРЛАГА	Зарлагын нийт дүн						
	Үүнээс	Үндсэн болон нэмэгдэл цалин					
		Нийгмийн даатгал, шимтгэл					
		Ус, дулаан, цахилгааны зардал					
		Шуудан холбооны зардал					
		Ном хэвлэлийн зардал					
		Хичээл практикийн зардал					
		Сургалтын лаборатори, тоног төхөөрөмж худалдан авах					
		Эрдэм шинжилгээний зардал					
		Шинээр барилга, байгууламж барих, худалдан авах					
		Оюутанд тэтгэлэг болгон зарцуулах зардал					
Бусад							
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	Үндсэн хөрөнгийн нийт дүн						
	Үүнээс	Барилга байгууламж					
		Сургалтын тоног төхөөрөмж					
		Ном хэвлэлийн зардал					
		Тавилга					
		Тээврийн хэрэгсэл					
		Бусад					

Зөвшөөрсөн/ Хянасан: / /

Судалгаа гаргасан: / /

Огноо:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2018 оны 03 дугаар сарын...ны өдрийн А/...
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**НЭГ СУРАЛЦАГЧИД НООГДОХ ЗАРДАЛ,
СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ТООЦОО**

Он	Зардал			Төлбөр	
	Нэг суралцагчид ноогдох зардал	Нийт суралцагчийн тоо	Нийт зардал	Нэг багц цагийн үнэ	Сургалтын төлбөрийн хэмжээ

Тайлбар: Хэрэв ялгаатай бол мэргэжил тус бүрээр гаргана.

Зөвшөөрсөн/Хянасан: ()
 Судалгаа гаргасан: ()

Огноо:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
 2018 оны 03 дугаар сарын...ны өдрийн А/...
 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТИЙН СУДАЛГААНЫ МАЯГТ

Сургалтын байгууллагын нэр:

Шалгуур	Тоо	Эх сурвалж
Тухайн орон нутгийн хүн амын тоо		
Хөдөлмөрийн насны хүн амын тоо		
Хөдөлмөрийн насны ажилгүй иргэдийн тоо		
ЕБС-ийн төгсөгчдийн тоо		

№	Мэргэжлийн индекс, нэр	Ажлын байрны эрэлт төлөв байдал	Харьяалагдаж буй бүс орон нутагт тухайн мэргэжлээр сургалт явуулж буй сургалтын байгууллагын тоо			Хамран сургах боломжтой аймаг, сумын нэр	Элсүүлэх суралцагчдын тоо			Жил бүр төлөвлөж буй суралцагчийн тоо			Түншлэн ажиллах байгууллага	
			Политехник коллеж	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв	Мэргэжлийн сургалтын /түр/ сургалтын байгууллага		Аж ахуй нэгж байгууллагын захиалгаар	ЕБС төгсөгчдөөс	Бусад	Хүсэлт гаргаж буй он	2 дахь жил / ... оны хичээлийн жил	3 дахь жил / ... оны хичээлийн жил	Аж ахуйн нэгжийн тоо	Гэрээтэй аж ахуй нэгж байгууллагын тоо

Зөвшөөрсөн/хянасан ()

Судалгаа гаргасан: ()

Огноо

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2018 оны 03 дугаар сарын...ны өдрийн А/...
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ШИНЭ МЭРГЭЖЛЭЭР СУРГАЛТ ЯВУУЛАХ ӨРГӨДӨЛ

МБС-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад

Өргөдөл гаргагчийн нэр:

Албан ёсны хаяг:

Сургалтын байгууллагын нэр:

Сургалтын байгууллагын хэв шинж:

Санал болгож буй нөхцөлүүд														
№	Мэргэжлийн нэр	Мэргэжлийн индекс	Сургалтын хэлбэр	Элсэгчдийн тоо	Сургалтын агуулгын багтаамж (чадамж, багц цаг)	Багшлах бүрэлдэхүүн				Сургалтын орчин (нэрээр бичих)				Төгсөгчдөд олгох боловсролын баримт бичиг:
						Үндсэн	Цагийн	Онолын	Дэдлагын	Онолын анги	Дэдлагын газар	Номын сан	Бусад	
1														<input type="radio"/> Мэргэжлийн диплом, <input type="radio"/> Мэргэжлийн үнэмлэх, бүрэн дунд боловсролын гэрчилгээ, <input type="radio"/> Мэргэжлийн үнэмлэх <input type="radio"/> Чадамжийн гэрчилгээ
2														

Өргөдөлд хавсаргах баримт бичгүүд:

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, түүний хавсралтын хуулбар хувь
2. Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн 2016 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 001 тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага”-ын дагуу урьдчилсан өөрийн үнэлгээний тайлан
3. Магадлан итгэмжлэлийн гэрчилгээний хуулбар, магадлан итгэмжлэлийн тайлан
4. Тэмдэгтийн хураамж төлсөн баримт
5. Удирдах зөвлөлийн шийдвэр
6. Тайлбар, үндэслэл

Энэ журамд заасан дараах хавсралтуудыг ирүүлнэ.

7. ЧСС-ын сургалтын хөтөлбөр, хичээлийн төлөвлөгөө /Загвар 4/
8. Багш нарын судалгаа /Загвар 7/
9. Сургалтын орчинд тавигдах шаардлага /Загвар 8/
10. Нэг суралцагчид ноогдох зардал, сургалтын төлбөрийн тооцоо /Загвар 11/
11. Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа /Загвар 12/

Боловсруулсан:()

Зөвшөөрсөн/ Хянасан: ()

Огноо:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2018 оны 03 дугаар сарын...ны өдрийн А/...
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГАХ ХҮСЭЛТ

Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн
төрийн захиргааны төв байгууллагад

Хүсэлт гаргагчийн нэр:
Албан ёсны хаяг:
Сургалтын байгууллагын нэр:
Сургалтын байгууллагын хэв шинж:

Хавсаргах баримт бичиг:

- Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралтын хуулбар
- Албан хүсэлт

Боловсруулсан:()

Зөвшөөрсөн/ Хянасан: ()

Огноо:

**ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ**

Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад

Өргөдөл гаргагчийн ургийн овог, эцэг эхийн нэр, өөрийн нэр:

Албан ёсны хаяг: /нэр, албан тушаал, хаяг, утас, факс, цахим шуудангийн хаяг/

Сургалтын байгууллагын нэр:

Сургалтын байгууллагын хэв шинж

Санал болгож буй нөхцөлүүд							
№	Техникийн боловсрол олгох мэргэжил	Мэргэжлийн индекс	Сургалтын хэлбэр	Суралцах хугацаа, жил	Элсэгчдийн тоо	Сургалтын агуулгын багтаамж (чадамж, багц цаг)	Төгсөгчдөд олгох боловсролын баримт бичиг: -Мэргэжлийн диплом -Мэргэжлийн үнэмлэх, бүрэн дунд боловсролын гэрчилгээ -Мэргэжлийн үнэмлэх -Чадамжийн гэрчилгээ

Өргөдөлд хавсаргах баримт бичгүүд:

1. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь 5-аас доошгүй жил мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа эрхэлж, элсэлтээ хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн төлөвлөж, төгсөгчдийн ажил эрхлэлт 80 хувиас доошгүйг нотолсон судалгаа, баримт
2. Техникийн боловсрол олгох сургалтын төлөвлөгөөг дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгатай уялдуулж, боловсруулан батлуулсан байх
3. Дотоодын болон гадаадын магадлан итгэмжлэлд орсон байх бөгөөд 2-оос доошгүй техникийн боловсролын сургалтын хөтөлбөрт магадлан итгэмжлэл хийлгэсэн нотолгоо
4. Багшлах бүрэлдэхүүний 40-өөс доошгүй хувь нь магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй, үйлдвэрлэл дээр 3-аас доошгүй жил ажилласан дадлага, туршлагатай багшлах эрхийн сургалтанд хамрагдсан байх
5. Мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрт заагдсан, мэргэшлийн түвшний шаардлагад нийцсэн сургалтын орчин, техник хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдсан байх /Загвар-8/
6. Сургалтын байгууллагын тогтвортой хөгжлийн бизнес төлөвлөгөөг боловсруулан баталж хэрэгжүүлсэн байх /5-10 жилээр/ гадаад хамтын ажиллагаа хэрхэн хөгжүүлсэн байдал
7. Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлсэн байдал
8. Политехник коллеж болох тухай удирдах зөвлөлийн шийдвэр
9. Багшлах боловсон хүчин, хүний нөөц /Загвар-7/
10. Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа /Загвар-12/

Өргөдөл гаргасан:/

Зөвшөөрсөн /Хянасан/...../

Огноо.....

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
...оны ... дугаар сарын...ны өдрийн А/...
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

... оны...сарын...-ны өдөр

Бүртгэлийн дугаар

СУРГАЛТЫН АЖИЛ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

.....
.....
(Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын хаяг, орших аймаг,
сум, баг, хороо, гудамжны нэр, байшингийн дугаар, тоот)

.....
.....
(Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын оноосон нэр, ангилал)

Мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, энэхүү тусгай зөвшөөрлийн хяналтын үзүүлэлт, нөхцөл, шаардлагыг мөрдөж, хавсралтад заасан мэргэжлийн чиглэл, түвшингийн боловсрол, мэргэжил эзэмшүүлэх сургалтын ажил эрхлэхийг зөвшөөрнө.

(Энэхүү тусгай зөвшөөрөл нь ...Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын ...оны ... А/... тоот тушаал, хавсралтын хамт хүчинтэй.)

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД

(Гарын үсэг)

(Тамга)

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
...оны ... дугаар сарын...ны өдрийн А/...
дугаар тушаалын гуравдугаар хавсралт

..... дугаартай тусгай зөвшөөрлийн хавсралт

.....
/Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэр/

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ ШААРДЛАГА

Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагын нэгж:

№	Индекс		Мэргэжил /Чадамж	Сургалтын төрөл	Сургалтын хэлбэр	Сургалтын хугацаа	Элсэгчдийн тоо	Багш		Сургалтын агуулгын багтаамж (багц цаг, чадамж, цаг)	Сургалтын анги, танхимын тоо	Дадлагын газар, лабораторийн тоо, төрөл	Нэг ээлжинд хичээллэх суудлын тоо	Төгсөгчдөд олгох боловсролын баримт бичиг	Мэргэшлийн түвшин	Тусгай зөвшөөрөл олгосон шийдвэр	Тусгай зөвшөөрөл хүчинтэй байх хугацаа	
	Үсгэн	Тоон						Үндсэн багшийн тоо	Гэрээт багшийн тоо									

Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн
төрийн захиргааны төв байгууллага

Нэгжийн дарга...../...../

/тэмдэг/

/нэр/

/гарын үсэг/

20 ... оны ... сарын ... өдөр

DO NOT COPY